



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024.10.21 № 21

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны  
326 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргасан нь сайшаалтай. Дээрх хуулиуд шинээр батлагдсантай холбогдуулан 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр "Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 326 дугаар тогтоолыг батлан гаргажээ.

Энэхүү тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, багш нарыг магистрын болон гадаад, дотоодод мэргэшүүлэх сургалтад суралцуулахад шаардагдах зардлыг 2024 оны төсвийн жилээс эхлэн төсвөөс санхүүжүүлэх талаар санал боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх" даалгаврыг тухайн үеийн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд өгсөн байна.
  - 1.1. Энэ хүрээнд 2024 оны улсын төсөвт хэдэн төгрөг төсөвлөж, бакалавр болон магистрын түвшинд хэдэн суралцагчид хэрхэн зарцуулсан мэдээллийг;
  - 1.2. Мөн 2025 оны улсын төсвийн төсөлд хэдэн төгрөг төсөвлөж, бакалавр болон магистрын түвшинд хэдэн суралцагчид хэрхэн зарцуулахаар төлөвлөж байгаа талаарх мэдээллийг;
2. Тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2-т "Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу багшийн хөгжлийг дэмжих төвүүдийг байгуулж, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах;" үүргийг тухайн үеийн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасан байна.

20240045

- 2.1. Энэ хүрээнд 2024 оны улсын төсөвт хэдэн багшийн хөгжлийн төвүүдийг байгуулахаар тусгаж, үүнд хэдэн төгрөг зарцуулж байгаа талаарх мэдээллийг;
- 2.2. Мөн 2025 оны улсын төсвийн төсөлд хэдэн багшийн хөгжлийн төвүүдийг байгуулахаар тусгаж, үүнд хэдэн төгрөг зарцуулахаар байгаа талаарх мэдээллийг;
3. Тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3-т "Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандарт, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, батлах" үүргийг тухайн үеийн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасан байна.  
-Энэ хүрээнд боловсруулж, баталсан Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандарт, холбогдох дүрэм, журмын талаарх мэдээлэл;
4. Тогтоолын 3 дугаар зүйлд "Багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах болон багш бүрийг компьютержуулах боломжийг судлан, төсөл, арга хэмжээний саналаа 2024 оноос үе шаттай хэрэгжүүлэхээр тооцож танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай." гэжээ.
- 4.1. Багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах чиглэлээр ямар төсөл, арга хэмжээ боловсруулж, 2024 онд хэдэн багшийг хамруулсан, 2025 онд хэдэн багшийг хамруулахаар төлөвлөж байгаа тухай мэдээллийг;
- 4.2. Багш бүрийг компьютержүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тухай мэдээллийг төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллага тус бүрээр гаргаж хангалтын хувь (хэдэн багштайгаас хэдэн багшид нь олгогдсоныг), компьютерийн марк, хүчин чадлын үзүүлэлтийг дэлгэрэнгүй хүснэгтийн хамт;
5. Тогтоолын 4 дүгээр зүйлд "Төрийн өмчийн багш бэлтгэх их сургуулийн хичээлийн болон дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай." гэжээ.
- 2024 оны улсын төсөвт Төрийн өмчийн багш бэлтгэх их сургуулийн хичээлийн болон дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд хэдэн төгрөгийг тусган, хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

20240045